



ЖИЛИЙН  
ТАЙЛАН  
2022



## АГУУЛГА

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ 2

Удирдлагын баг 3

2022 оны үйл ажиллагааны тойм 4

Гишүүнчлэл 6

Гишүүдийн хуримтлал 7

Хөрөнгө оруулалт, өгөөж 8

Нөөц сан бүрдүүлэлт, орлого зардал 9

Санхүүгийн тайлан 10-15

## ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм гишүүн байгууллага, гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе! Бид та бүхэндээ 2022 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайлангаа уламжлал ёсоор танилцуулж байна.

Тэтгэврийн Ууган Сан /Сан/ 2022 оны эцсийн байдлаар нийт 1344 гишүүнтэй, 7.0 тэрбум төгрөгийн хуримтлалтай болоод байна. 2022 онд бид дотоод үйл ажиллагаандаа чамлахааргүй өөрчлөлт шинэчлэл хийлээ.

Тухайлбал байгууллагын тэтгэврийн хөтөлбөрийн үйлчилгээгээ урт ба богино шатлалтай буюу сонголттой болгосон. Хөрөнгө оруулалт эрсдэлийн удирдлагын бодлогодоо өөрчлөлт оруулж, хөрөнгө оруулалтын багц сонголтын хадгаламж суурийг бууруулж, хувьцаа-компанийн бондод хөрөнгө оруулах боломжийг багц тус бүрт 15 хувиар нэмэгдүүллээ.

Гэсэн хэдий ч 2022 онд хэрэгжсэн ковидын хуулийн хязгаарлалт, зээлийн хүү бууруулах бодлогын нөлөөгөөр Монголбанк бодлогын хүүгээ 6 хувиас 13 хувь хүртэл 5 удаа өөрчилснөөс өмнөх оны 1 жилийн хугацаатай хадгаламжийн хүү үнэгүйдэж, 3 сараас дээш хугацааны хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад бэрхшээлтэй жил байлаа. Энэ жил бид анх удаа нөөц сангаас зарцуулалт хийж, гишүүдэд хуваарилах өгөөжийг 195 сая төгрөгөөр нэмэгдүүлэн Монголбанкны бодлогын хүүний жигнэсэн дундаж буюу 9,53 хувьд хүргэлээ.

УИХ-аар хэлэлцэгдэх жагсаалтад байсан “Хувийн нэмэлт тэтгэврийн тухай” хуулийн төсөл 2023 оны хаврын чуулганаар хэлэлцэгдэхээр болсон явдал нь бидний олон жилийн хүлээлтэд найдлага төрүүлсэн мэдээ байсныг дуулгахад таатай байна.

Сайхан ирээдүйг бүтээх хүслээ бидэнтэй нэгтгэн шинээр нэгдсэн Супер проб /Мөнгөнгүүр эмнэлэг/, Плас саплай инженеринг, түүнчлэн гишүүнчлэлээ идэвхжүүлэн илүү олуулаа болж эргэн нэгдсэн Бодь интернэшнл, Ашид Голомт ББСБ мөн Голомт банкныхаа удирдлагууд, гишүүддээ ТАЛАРХАЛ илэрхийлж, амжилт хүсье.

ХҮНДЭТГЭСЭН,  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Н.МӨНХЖАРГАЛ

## УДИРДЛАГЫН БАГ

### Удирдах зөвлөл

Удирдах зөвлөл нь сангийн эрх барих дээд байгууллага бөгөөд сангийн дүрэм, бодлого, журам, бизнес төлөвлөгөө, жилийн тайланг хэлэлцэн батлах, гүйцэтгэх захирлыг сонгон шалгаруулж, томилох эрх үүрэгтэй.



Гишүүн Г.Эрдэнэчимэг  
Үүсгэн байгуулагчаас томилогдсон  
Бодь интернэшнл ХХК-ийн  
Үйл ажиллагаа хариуцсан захирал



Гишүүн, ТУС-ийн гүйцэтгэх захирал  
Н.Мөнхжаргал  
Үүсгэн байгуулагчаас томилогдсон  
Голомт банкны Комплаенсийн  
хэлтсийн ахлах мэргэжилтэн,



Дарга Г.Ганболд  
Үүсгэн байгуулагчаас томилогдсон  
Голомт банкны ерөнхийлөгч



Гишүүн Н.Долгормаа  
Бүх гишүүдийн төлөөлөл  
Голомт банкны Бүртгэл тооцооны  
газрын Салбарын мониторингийн  
хэлтсийн Захирал



Гишүүн А.Ганчимэг  
Бүх гишүүдийн төлөөлөл  
Голомт банкны Байгууллагын  
банкны газрын Бизнес хамтын  
ажиллагааны хэлтсийн захирал

### Хяналтын зөвлөл

Хяналтын зөвлөл нь сангийн санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд хяналт тавьж ажилладаг.



Гишүүн Г.Гүрбазар  
Үүсгэн байгуулагчаас томилогдсон  
Голомт банкны Санхүү удирдлагын  
газрын Төлөвлөлт үнэлгээний  
хэлтсийн захирал



Дарга Х.Пүрэвдорж  
Бүх гишүүдийн төлөөлөл  
Голомт банкны Захиргааны газрын  
Захирал



Гишүүн Д.Цэвэлмаа  
Бүх гишүүдийн төлөөлөл  
Голомт банкны Баянзүрх салбарын  
захирал

### Хөрөнгө оруулалтын хороо

Хөрөнгө оруулалтын хороо нь Удирдах зөвлөлөөс зөвшөөрсөн эрх хэмжээнд хөрөнгө оруулалтыг удирдах, хянах үүрэгтэй.



Гишүүн Б.Содболор  
Голомт банкны Нөөцийн  
удирдлагын газрын захирал



Дарга Н.Мөнхжаргал  
Тэтгэврийн Ууган Сангийн  
Гүйцэтгэх захирал



Гишүүн Д.Нямдаваа  
Голомт банкны Зээлийн газрын  
Том зээлийн хэлтсийн захирал

### Гүйцэтгэх баг

Ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүргийн дагуу сангийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна.



Бизнес хөгжлийн менежер  
Ө.Эрдэнэчимэг



Санхүү, үйл ажиллагаа хариуцсан  
менежер Л.Баярмаа

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ

- 2022 онд санд 342 гишүүн шинээр элсэж, 378 гишүүн сангаас гарч, оны эцсийн байдлаар 1344 гишүүнтэй байна. Шинээр Супер проб (Мөнгөн гүүр эмнэлэг), Плас саплай ХХК нэгдэж гишүүн байгууллагын тоо 10 боллоо. Ашид голомт ББСБ ХХК, Бодь интернэшнл ХХК шинэ хөтөлбөрөөр гишүүнчлэлээ идэвхжүүллээ.



- Гишүүн байгууллагуудын хүний нөөцийн арга хэмжээнд оролцож ажилтнуудад ТУС сангийн талаар мэдээлэл өгч ажиллаа. Гишүүдийн дунд зохион байгуулдаг “ТУС-ч Найз” урамшуулалт аян, Зуслангийн нээлт зэрэг уламжлалт арга хэмжээг зохион байгуулсан.



- 2022 оны өгөөж хуваарилсанаар нийт гишүүдийн хуримтлал 7.05 тэрбум төгрөг боллоо. Гишүүдэд 1.1 тэрбум төгрөгийн хуримтлал, 0.6 тэрбум төгрөгийн өгөөж нэмэгдлээ. Сангаас гарсан гишүүдийн тооцоотой холбоотой 1.3 тэрбум төгрөгийн хуримтлал сангаас гарсан байна.


- Хөрөнгө оруулалт, эрсдэлийн удирдлагын бодлогын өөрчлөлт, гишүүдийн багц сонголттой холбоотой 2022 онд жилийн дунджаар нийт 6,4 тэрбум төгрөгийн 75 хувийг харилцах хадгаламжид, 15 хувийг компанийн бондод, 10 хувийг хувьцаанд хөрөнгө орууллаа.
- 2022 онд Багц 1-ийг сонгосон гишүүдийн хуримтлалд 11.61 хувь, Багц 2-т 10.05 хувь, Багц 3-т 8.50 хувийн өгөөж хуваариллаа.
- Бүх гишүүдийн хурлаа 3-р сард зохион байгуулж, гишүүдийн ирц оролцоо 82,2 хувь байлаа. Хурлаар 2021 оны тайланг танилцуулж, хөрөнгө оруулалтын багц сонголтын бүтцэд өөрчлөлт оруулсантай холбоотой нийт гишүүддээ багц өөрчлөх боломж олголоо.
- Удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй, харин хөрөнгө оруулалтын хорооны нэг гишүүн ажлаас гарсан тул чөлөөлөгдөж, нэг гишүүнийг нөхөн томиллоо. Гүйцэтгэх захирал Н.Мөнхжаргалын контрактын гэрээг дахин нэг жилээр сунгалаа.
- Сангийн дүрмээ шинэчлэн найруулж баталлаа. Байгууллагын тэтгэврийн хөтөлбөрөө урт болон богино сонголттой болгож үйлчилгээний ерөнхий нөхцөлдөө өөрчлөлт орууллаа. Гишүүн байгууллага, гишүүний гэрээнүүдийг шинэ, дүрэм журамд нийцүүлж, шинэчлэн баталлаа.
- Дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбоотой 142.6 төгрөгийн үйл ажиллагааны орлоготой, 141.6 сая төгрөгийн үйл ажиллагааны зардалтай ажиллаа.
- 2022 оны санхүүгийн тайлан, бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлээ Гроут Финанс Аудит ХХК-р хөндлөнгийн аудит хийлгэв.

## ГИШҮҮНЧЛЭЛ

2022 онд санд 342 гишүүн шинээр элсэж, 378 гишүүн сангаас гарсан тул хуримтлалыг олголоо. Санд шинээр элссэн 342 гишүүний 189 нь Голомт банкнаас, 142 нь бусад гишүүн байгууллагаас, 11 гишүүн хувиараа элслээ. Гишүүдийн дунд зохион байгуулдаг “ТУС-ч Найз” урамшуулалт аянаа зохион байгуулж, нийт 52 гишүүн хамрагдаж, 10 гишүүнд болзол хангасан тул урамшуулал олголоо.

Нийт 1344 гишүүний 67 хувь нь 0 – 4 жил, 19 хувь нь 5-8 жил, 14 хувь нь 9 ба түүнээс дээш жил хуримтлуулж буй гишүүд байна. Нийт 95 гишүүн санд 10 дээш жил хуримтлуулж, нэрийн дансан дахь хуримтлалаа 100 хувь авах эрхтэй байна.

Гишүүдийн хөдөлгөөн




Хүснэгт 1. Сангийн гишүүдийн хуримтлалын хэмжээ, гишүүнчлэлийн жилээр (сая төгрөгөөр)

Гишүүний жил	Гишүүний тоо		Хуримтлал		
	Тоо	Хувийн жин	1 гишүүний дундаж	Нийт	Хувийн жин
0-4 жил	903	67%	1.41	1274.25	18%
5-8 жил	257	19%	4.20	1080.57	15%
9 ба түүнээс дээш	184	14%	25.53	4696.79	67%
НИЙТ	1344	100%	5.25	7051.61	100%


2022 онд нийт 378 гишүүн сангаас гарч, 1.38 тэрбум төгрөгийн хуримтлал тооцож олгосон байна. Нийт гарсан гишүүдийн 48.9 хувь буюу 185 гишүүн өөрийн хүсэлтээр сангаас гарч, 46.6 хувь буюу 176 гишүүн хөдөлмөрийн гэрээ цуцалж, 2 гишүүн тэтгэврийн насанд хүрч хувийн тэтгэврээ авсан байна. Идэвхгүй буюу ажлаас гарч, холбоо барих боломжгүй болсон 46 гишүүнийг олж, хуримтлалын тооцоо хийсэн нь сангаас гарсан гишүүдийн тоо өндөр болоход нөлөөллөө.

## ГИШҮҮДИЙН ХУРИМТЛАЛ



2022 онд гишүүн болон гишүүн байгууллагаас нийт 1.08 тэрбум төгрөг гишүүдийн нэрийн дансанд нэмэгдэж, сангаас 0.61 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын өгөөж хуваариллаа. Хуримтлалаа авсан 378 гишүүнтэй холбоотойгоор сангаас 1.39 тэрбум төгрөгийн хуримтлал гарч, оны эцсийн байдлаар сангийн 1344 гишүүн 2022 оны өгөөж орсон дүнгээр нийт 7.05 тэрбум төгрөгийн хуримтлалтай байна.

### Сангаас гарсан гишүүдийн тооцоо



### Хүснэгт 2. Гишүүдийн хуримтлалын хөдөлгөөн (сая төгрөгөөр)

Оны эхний үлдэгдэл	6,746.48
Нэмэгдсэн хуримтлал	1,078.10
Хасагдсан хуримтлал	(1,386.30)
2022 оны өгөөж	613.55
Оны эцсийн үлдэгдэл	7,051.81

- Гишүүдэд цэвэр олгосон хуримтлал
- ХХОАТ-т шилжүүлсэн
- Байгууллагад буцаасан хуримтлал
- Нөөц санд үлдэх өгөөж




## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ӨГӨӨЖ

2022 онд бид Хөрөнгө оруулалтын, эрсдэлийн удирдлагын бодлогоо шинэчилж, бүх гишүүддээ хөрөнгө оруулалтын багц сонголтоо өөрчлөх боломжийг олгож ажилласан. Нийт гишүүдийн 18 хувь нь Багц 1-ийг, 31 хувь нь Багц 2-ыг, 51 хувь нь Багц 3-ыг сонгосон байна.


Бид 2022 онд жилийн дунджаар 6.43 тэрбум төгрөгийн хуримтлалыг удирдан ажилласан бөгөөд гишүүдийн багц сонголтын дагуу Зэрэглэл 1-ийн хөрөнгө оруулалтад 68 хувийг, Зэрэглэл 2-ын хөрөнгө оруулалтад 32 хувийг байршууллаа.

Ковидын хуулийн хязгаарлалттай холбоотой банкны тусгай хадгаламжийн хүүг хязгаарласан, хугацаагүй хадгаламжид хүү тооцоогүй, Монголбанк бодлогын хүүгээ 6 хувиас 13 хувь хүртэл 5 удаа өөрчилснөөс өмнөх оны 1 жилийн хугацаатай хадгаламжийн хүү үнэгүйдэж, 2021 онд өндөр өсөлттэй байсан хувьцааны ханш унасан зэрэг шалтгаанаас сангийн өгөөж 6,49% болсон. Гэсэн хэдий ч бид гишүүдийнхээ хуримтлалын үнэ цэнийг нэмэгдүүлэх үүднээс нөөц сангаас 195.4 сая төгрөг зарцуулан 2022 оны дундаж өгөөжийг Монголбанкны бодлогын хүүний жигнэсэн дундаж буюу 9.53 хувьд хүргэлээ. Үүний үр дүнд Багц 1-д 11.59 хувь, Багц 2-т 10.05 хувь, Багц 3-т 8.51 хувийн өгөөж тус тус хуваариллаа.


Гишүүдийн багц сонголт хуримтлалаар



Хөрөнгө оруулалт төрлөөр



Хөрөнгө оруулалтын өгөөж багц тус бүрээр



## НӨӨЦ САН БҮРДҮҮЛЭЛТ, ОРЛОГО ЗАРДАЛ


ТУС гишүүдийнхээ хуримтлалын үнэ цэнийг хадгалах зорилгоор 2012 оноос Эрсдэл тогтворжилтын сангийн журам батлан нөөц сан бүрдүүлж ирсэн бөгөөд 2022 онд Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийн хамтарсан хурлын шийдвэрээр нөөц сангаас 195.4 сая төгрөг зарцуулж, гишүүдэд хуваарилах өгөөжийг нэмэгдүүллээ.

Хүснэгт 3. Нөөц сангийн хөдөлгөөн (сая төгрөгөөр)

Эхний үлдэгдэл	1,275.89
2021-2022 онд гарсан гишүүдийн өгөөж	131.28
Гишүүдийн өгөөжийг нэмэгдүүлсэн*	-195.40
Эцсийн үлдэгдэл	1,211.8

ТУС нь 2022 онд 34.26 сая төгрөгийн гишүүний татвар, 108,3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын хүүгийн орлого, нийт 142.62 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, үйл ажиллгаатай холбоотой зардал 141,56 сая төгрөг байлаа. Үйл ажиллагааны зардлын төсвийн гүйцэтгэл 75 хувь биелсэн.

Сангийн орлого, зарлага (сая төгрөгөөр)



Хүснэгт 4. Сангийн үйл ажиллагааны зардал

Үзүүлэлт	Төсөв	Гүйцэтгэл	Хувь
I. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	97.5	53.9	55%
УЗ, ХЗ хурал болон, аудитын зардал	21.3	2.6	12%
Програм, Вэб хөгжүүлэлт	53.6	39.8	74%
Зар сурталчилгаа	12.7	8.2	65%
Сургалт	5.8	1.3	22%
Бичиг хэргийн зардал	1.2	0.5	42%
Бусад зардал	2.9	1.5	52%
II. ЦАЛИН ХӨЛСНИЙ ЗАРДАЛ	98.5	92.8	94%
НИЙТ ЗАРДАЛ	196.0	146.7	75%

# САНХҮҮГИЙН ТАЙЛАН



ГРОУТ ФИНАНС АУДИТ ХХК

## ГРОУТ ФИНАНС АУДИТ ХХК

Аудит нягтлан бодох бүртгэл, хөрөнгийн үнэлгээ,  
бизнесийн зөвлөгөө

Монгол Улс, Улаанбаатар хот 14200, Баянгол дүүрэг,  
2 дугаар хороо, Эрхи Цогцолбор төв 603 тоот  
И- мэйл: info@growthfinance.mn, Утас: 976-9909 4391

Огноо 2023.02.15 Дугаар 02/03

“Тэтгэврийн Ууган Сан” ТББ-ийн  
Хувьцаа эзэмшигчид

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### Санхүүгийн Тайлангийн Аудитын Талаарх Тайлан

#### Дүгнэлт

Тэтгэврийн Ууган Сан Төрийн бус байгууллага /цаашид ТУС ТББ гэх /- ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол бүхий нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, Тэтгэврийн Ууган Сан ТББ-ын санхүүгийн тайлан нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, цэвэр хөрөнгийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн Үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (цаашид АОУС гэх)-ын дагуу хийж гүйцэтгэлээ. Уг стандартын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэхүү тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх Аудиторын үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Эдгээр стандарт нь санхүүгийн тайланг материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн гэсэн зохих нотолгоог олж авах зорилгоор аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, мөн мэргэжлийн ёс зүйн шаардлагуудыг даган мөрдөхийг биднээс шаарддаг. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай, зохих үндэслэл болно гэдэгт бид итгэж байна.

#### Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн Тайланд хүлээх Үүрэг Хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид СТОУС гэх)-ын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах үүрэг, хариуцлага хүлээх бөгөөд залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг алдаанаас ангид санхүүгийн тайланг

бэлтгэхэд зайлшгүй шаардлагатай дотоод хяналтыг тодорхойлох үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ удирдлага нь тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх, Тэтгэврийн Ууган Сан ТББ-ын чадамжийг үнэлж, тодруулах, шаардлагатай бол татан буулгахаар, эсвэл үйл ажиллагааг нь зогсоохоор, эсвэл нингэхээс өөр бодит хувилбар байхгүйгээр төлөвлөснөөс бусад тохиолдолд тасралтгүй ажиллагаатай холбоотой асуудал болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй ажиллагааны зарчмыг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ. Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь төлөөлөгчийн газрын санхүүгийн тайлагналын үйл ажиллагаанд хяналт тавих үүрэг хариуцлага хүлээнэ.

### ***Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага***

Бидний зорилго нь санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар ул үндэслэлтэй нотолгоо олж авах, өөрийн дүгнэлтийг багтаасан тайлан гаргах юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-н дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлж байна гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

Бид АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг байдлаар мэргэжлийн шүүмж ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримталан ажилладаг ба бид,

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, уг эрсдэлийг үнэлэн, эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын тохиромжтой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын ул үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн ТУС ТББ-н тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал нь Төлөөлөгчийн газрын тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүйд хүргэж болно.

- Тодруулгыг багтаагаад санхүүгийн ерөнхий тодруулга, бүтэц, агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.



Гроут Финанс Аудит ХХК  
Монгол улс, Баянгол дүүрэг, 2-р хороо  
Баруун 4 зам Улаанбаатар 14200  
603 тоот, Эрхи цогцолбор,

Энэхүү тайлан нь аудитын тайлангийн өдөр буюу 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөр хүчин төгөлдөр үйлчилнэ. Аудитын тайлангийн өдөр болон энэхүү тайланг хэрэглэх хугацааны хооронд тохиолдож болох аливаа тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдал нь уг санхүүгийн тайлан болон тодруулгад материаллаг нөлөө үзүүлж болох юм. Уг тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдлын нөлөөллийг дээрх аудитын тайланд тусгаагүйг анхаарна уу.

ТЭТГЭВРИЙН УУГАН САН ТББ  
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

<i>(Төгрөгөөр)</i>	<i>Тодруулга</i>	<b>2022.12.31</b>	<b>2021.12.31</b>
<b>ХӨРӨНГӨ</b>			
<b>Эргэлтийн хөрөнгө</b>			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	4	118,478,594.04	154,204,069.78
Богино хугацаат хөрөнгө оруулалт	5	6,850,000,000.00	6,750,000,338.00
Дансны авлага	6	328,596,849.32	281,060,720.26
Бараа материал	7	390,000.00	935,266.67
Урьдчилж төлсөн зардал / тооцоо	8	59,411,250.00	19,923,750.00
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>		<b>7,356,876,693.36</b>	<b>7,206,124,144.71</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>			
Үндсэн хөрөнгө	9	175,960.98	887,731.82
Биет бус хөрөнгө	10	945,000.00	1,125,000.00
Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө	11	962,367,465.69	934,943,979.06
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>		<b>963,488,426.67</b>	<b>936,956,710.88</b>
<b>ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>8,320,365,120.03</b>	<b>8,143,080,855.59</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>			
<b>Өр төлбөр</b>			
Дансны өглөг	12	58,361.63	14,419.67
Цалингийн өглөг	13	13,205,146.64	9,931,585.64
Татварын өглөг	14	32,698,726.01	28,078,817.72
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>		<b>45,962,234.28</b>	<b>38,024,823.03</b>
<b>Урт хугацаат өр төлбөр</b>			
Бусад урт хугацаат өр төлбөр	15	7,051,829,101.55	6,819,430,871.20
<b>Нийт өр төлбөрийн дүн</b>		<b>7,097,791,335.83</b>	<b>6,857,455,694.23</b>
<b>Эздийн өмч</b>			
Хязгааргүй нөөц		1,211,783,454.88	1,275,892,159.64
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		-	-
Хуримтлагдсан ашиг (алдагдал)		10,790,329.32	9,733,001.72
<b>Эздийн өмчийн дүн</b>		<b>1,222,573,784.20</b>	<b>1,285,625,161.36</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>		<b>8,320,365,120.03</b>	<b>8,143,080,855.59</b>

**ТЭТГЭВРИЙН УУГАН САН ТББ  
ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

<i>(Төгрөгөөр)</i>	<i>Тодруу лга</i>	<b>2022</b>	<b>2021</b>
Гишүүдийн татвар	16	34,260,250.01	34,287,649.31
Бусад орлого		-	406,018.40
Хөрөнгө оруулалтын орлого	17	108,356,701.69	131,628,574.24
<b>Үндсэн үйл ажиллагааны орлого</b>		<b>142,616,951.70</b>	<b>166,322,241.95</b>
<b>Үндсэн үйл ажиллагааны зардал</b>	18	<b>141,216,747.62</b>	<b>103,234,981.39</b>
<b>Үндсэн үйл ажиллагааны үр дүн</b>		<b>1,400,204.08</b>	<b>63,087,260.56</b>
<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>			
Валютын ханшийн өөрчлөлтөөс үүссэн олз (гарз)		-	(59,116,568.00)
Орлогын албан татварын зардал		342,876.49	148,868.89
<b>Тайлант оны цэвэр үр дүн</b>		<b>1,057,327.59</b>	<b>122,054,959.67</b>

ТЭТГЭВРИЙН УУГАН САН ТББ  
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

(Төгрөгөөр)	2022	2021
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого:	6,340,295,734.92	5,670,820,299.66
Гишүүдийн татвараас орсон мөнгө	34,258,250.01	34,259,649.31
Бусад	6,306,037,484.91	5,636,560,650.35
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага:	5,120,984,229.51	5,417,271,965.58
Ажилчдад олгосон мөнгө	79,667,854.39	78,394,013.19
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	9,814,243.68	8,087,610.07
Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	2,340,000.00	1,658,000.00
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	30,000.00	-
Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн бусад мөнгө	221,147,150.57	19,923,750.00
Төлсөн татвар	74,800,931.69	67,161,112.68
Бусад зардалд төлсөн мөнгө	4,733,184,049.18	5,242,047,479.64
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>1,219,311,505.41</b>	<b>253,548,334.08</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Худалдсан хөрөнгө оруулалтын орлого	431,785,656.01	603,837,342.34
Худалдаж авсан хөрөнгө оруулалт	(1,625,246,090.00)	(987,584,851.19)
<b>Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(1,193,460,433.99)</b>	<b>(383,747,508.85)</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Банкны зээл /Гишүүдийн хуримтлал/	1,098,239,492.51	908,106,675.64
Урт хугацаат өрийн тайлангийн хугацааны төлөлт	(1,159,816,039.67)	(973,525,498.69)
<b>Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(61,576,547.16)</b>	<b>(65,418,823.05)</b>
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(35,725,475.74)</b>	<b>(195,617,997.82)</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>154,204,069.78</b>	<b>349,822,067.60</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>118,478,594.04</b>	<b>154,204,069.78</b>